| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 969,800.00 | 811,500.00 | 158,300.0 | 83.7 |
| 210807 | Газрын төлбөр | 22,000.00 | 00.00 | 22,000.0 | 0.0 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 8,589,600.00 | 8,390,602.00 | 198,998.0 | 97.7 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 8,589,600.00 | 8,390,602.00 | 198,998.0 | 97.7 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 237,654,400.00 | 234,838,417.00 | 2,815,983.0 | 98.8 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 237,654,400.00 | 234,838,417.00 | 2,815,983.0 | 98.8 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 113,394,500.00 | 113,087,949.00 | 306,551.0 | 99.7 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 122,339,900.00 | 119,859,768.00 | 2,480,132.0 | 98.0 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,920,000.00 | 1,890,700.00 | 29,300.0 | 98.5 |

Говьсүмбэр аймгийн Эрүүл мэндийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

| | | | | | |
|-------------|---|----------------|----------------|------------|-------|
| | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 670,672,000.00 | 670,789,817.00 | -117,817.0 | 100.0 |
| 1310 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 670,672,000.00 | 670,672,000.00 | 0.0 | 100.0 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 670,672,000.00 | 670,672,000.00 | 0.0 | 100.0 |
| 1340 | НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 00.00 | 117,817.00 | -117,817.0 | 0.0 |
| 134001 | Нийгмийн даатгалын сангаас санхүүжих | 00.00 | 117,817.00 | -117,817.0 | 0.0 |
| 62 | АЖИЛЛАГСАДЫН ТОО | 24 | 16 | 8.0 | 66.7 |
| 620001 | Удирдах ажилтан | 01 | 01 | 0.0 | 100.0 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 16 | 08 | 8.0 | 50.0 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 07 | 07 | 0.0 | 100.0 |

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Говьсүмбэр аймгийн Эрүүл мэндийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд зарцуулалт болон худалдан авалттай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний үндсэн дээр 2022 оны “Эн Ай Ти Эс баланс Аудит” ХХК-ийн ахлах аудитор Ц.Энхтуяа, захирал Ш.Ичинхорлоо нар гүйцэтгэж, анхан шатны чанарын хяналтыг аудитын менежер И.Туяа хэрэгжүүлж, дараагийн шатны чанарын хяналтыг Төрийн аудитын газрын аудитын менежер Г.Наранбаяр, дарга, тэргүүлэх аудитор Б.Сарантуяа нар хэрэгжүүлэв.

Говьсүмбэр аймгийн Эрүүл мэндийн газар 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Эн Ай Ти Эс Баланс Аудит ХХК-д хянуулахаар 2022 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 01/33 тоот албан бичгээр хуульд заасан хугацаанд ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Говьсүмбэр аймгийн Эрүүл мэндийн газар нь үйл ажиллагааны эрхэм зорилгоо “Бид ёс зүйн хариуцлагад суурилсан тусламж үйлчилгээг өндөр түвшинд үзүүлэх” гэж тодорхойлсон байна.

Дээрх зорилгын хүрээнд үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Нийтийн эрүүл мэндийн тусламжийн бодлого, хэрэгжилтийг зохицуулах;
- Харьяа нутаг дэвсгэрийн эрүүл мэндийн байгууллагын хүний нөөцийг дэмжин хөгжүүлэх
- Анхан шатлалын эрүүл мэндийн тусламж үйлчилгээний анхан шатлалын эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааны гүйцэтгэлд тогтмол хяналт тавин ажиллана
- Нийтийн эрүүл мэндийн тусламжийн бодлого, хэрэгжилтийг зохицуулах;

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг дараах хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Нийгмийн даатгалын тухай хууль;
- Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”;
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаал “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”;
- Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” ;
- Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/324 тоот тушаал “Эмнэлгийн тоног төхөөрөмжийг хуваарилах, үндсэн хөрөнгөнд бүртгэх тухай”

- Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/337 тоот тушаал “Корона вируст халдвар (Ковид 19)-ын вакцинаар дархлаажуулах тухай”,
- Эрүүл мэндийн сайдын 2021 оны 2/3389 тоот тушаалаар “... халдварын голомтот бүсэд ажиллаж буй албан хаагчдын ажилласан хугацаанд ногдуулан цалин, нэмэгдэл хөлс олгох” тухай эрүүл сэндийн байгууллагад өгсөн чиглэл.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцээгүй, тус байгууллагын үйл ажиллагааны бүртгэл, тайлагналын онцлог, холбогдох шаардлагыг хангахгүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Говьсүмбэр аймгийн Эрүүл мэндийн газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу санхүүгийн тайлан бэлтгэж, тайлагнасан байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны баталсан төсвийн нийт зардлын хүлээгдэж буй гүйцэтгэлийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны баталсан төсвийн зардлын хүлээгдэж буй гүйцэтгэл 696,587.7 мянган төгрөгийн 2.0 хувь буюу 13,931.7 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75.0 хувиар тогтоов.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлын суурь үзүүлэлтийн дүн жилийн төсвийн гүйцэтгэлийн их биш зөрүүтэй байгаа тул аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Говьсүмбэр аймгийн Эрүүл мэндийн газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 665,076.4 мянган төгрөгөөр өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр, засгийн газрын оролцоо данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|----------|----------------|-----------------|--------------|
| Б | 1 | 2 | 3=2-1 |

| | | | |
|---|------------------|------------------|------------------|
| Мөнгөн хөрөнгө | 1,913.5 | 1,913.5 | 0.0 |
| Авлага | | 5,079.4 | 5,079.4 |
| Бараа материал | 104,908.1 | 146,516.9 | 41,608.8 |
| Үндсэн хөрөнгө | 166,916.2 | 785,304.4 | 618,388.2 |
| Нийт хөрөнгийн дүн | 273,737.8 | 938,814.2 | 665,076.4 |
| Богино хугацаат өр төлбөр | - | 5,020.0 | 5,020.0 |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 273,737.8 | 933,794.2 | 660,056.4 |
| Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн | 273,737.8 | 938,814.2 | 665,076.4 |

Тайлант оны эцэст авлага 5,079.4 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь дээд шатны байгууллагаас ирүүлсэн нэмэлт санхүүжилтийн орлогыг Сангийн яамны төв төрийн сан татан төвлөрүүлсэн ба төв төрийн сантай тооцоо нийлж авлага дансанд бүртгэж, тайлагнасангай холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 41,608.8 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь дээд шатны болон бусад байгууллагаас үнэ төлбөргүй шилжиж ирсэн эм, эмнэлгийн хэрэгслээс аймгийн эрүүл мэндийн байгууллагуудад хуваарилагдаагүй болон нөөцийн эм, эмнэлгийн хэрэгслийн үлдэгдэл өндөр байгаагаас шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгийн данс 785,304.4 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байгаа нь өмнөх оноос 4.7 дахин буюу 618,388.2 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна. Үндсэн хөрөнгө нэмэгдэхэд аймгийн нэгдсэн эмнэлгээс 587,518.7 мянган төгрөгийн барилга байгууламж, ХӨСҮТ-с 35,716.8 мянган төгрөгийн эмнэлгийн тоног төхөөрөмж, ЭМЯ-наас 19,655.5 мянган төгрөгийн компьютерыг тус тус үнэ төлбөргүй шилжүүлэн авсан, улсын төсвийн хөрөнгөөр 12,500.0 мянган төгрөгийн компьютер худалдан авсан зэргээр 655,390.3 мянган төгийн хөрөнгө хүлээн авч бүртгэж, тайлагнасангай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 933,794.2 мянган төгрөг болж өмнөх оноос 660,056.4 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант онд үнэ төлбөргүй хүлээж авсан 587,518.7 мянган төгрөгийн барилга байгууламж, 55,372.3 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг үнэ төлбөргүй орлогоор хүлээн авсантай холбоотой байна.

Говьсүмбэр аймгийн Эрүүл мэндийн газрын санхүүгийн үр дүнгийн тайлангаарх нийт орлого өмнөх оноос 2,885,963.5 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

Тайлант оны орлого нэмэгдэхэд дараах орлогын өөрчлөлтүүд нөлөөлжээ. Үүнд:

- Урсгал үйл ажиллагааны санхүүжилт 24,856.7 мянга;
- Нэмэлт санхүүжилтийн орлого 533,399.1 мянган төгрөгөөр
- Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого 2,332,563.5 мянган төгрөгөөр тус тус өссөн байна.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаарх нийт зардал 1,290,113.8 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 389,448.9 мянган төгрөг буюу 43.2 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Тайлант онд цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал 26,254.8, хангамж бараа материалын зардал 20,919.8, бараа үйлчилгээний зардал 94,0323.6, урсгал шилжүүлэг 520,264.7 мянган төгрөгөөр тус тус өссөн байна.

Урсгал шилжүүлгийн дүн өндөр байгаа нь коронавирус (ковид 19) цар тахлын үед ажилласан эрүүл мэндийн байгууллагын ажиллагсдад олгосон нэг удаагийн тэтгэмж, урамшуулал болон хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны нэмэгдэл олгосноос шалтгаалсан байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Эрүүл мэндийн газрын 2021 оны зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон нийт зардлыг 773,005.0 мянган төгрөгөөр баталсан байна.

Төсвийн тодотголоор улсын төсвийн санхүүжилтийг 670,672.0 мянган төгрөгөөр баталж, анх баталсан төсвөөс 102,333.0 мянган төгрөг буюу 13.2 хувиар бууруулан баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөр, 4 зориулалт арга хэмжээг улсын төсвөөс санхүүжүүлэхээр 670,672.0 мянган төгрөгийг баталж, зарцуулжээ.

Тайлант оны улсын төсвийн санхүүжилтийг бүрэн авч зарцуулсан байна.

Баталсан нийт зардал 656,136.8 мянган төгрөг буюу 97.8 хувийн гүйцэтгэлтэй гарч 14,535.2 мянган төгрөг буюу 2.2 хувиар хэмнэгдсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2.2 хувиар хэмнэгдсэн нь зарим зардлуудын хэмнэлттэй холбоотой байна. Тухайлбал, Ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардал 7,318.7 мянга буюу 15.5 хувь, Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 592.3 мянга буюу 3.4 хувиар, урсгал шилжүүлэг 2,816.0 мянга буюу 1.2 хувиар, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардал 195.4 мянга буюу 7.5 хувиар тус тус хэмнэгдсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд дээд шатны төсвийн захирагчаас 310,045.7 мянга, орон нутгийн төсвөөс 140,199.0 мянга, төрийн болон орон нутгийн өмчит этгээдээс өгсөн хандив тусламжийн орлого 140,472.2 мянга, нийт 590,717.0 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс цалин хөлс, нэмэгдэлд 14,889.5 мянга, хангамж, бараа материалын зардалд 16,006.4 мянга, нормативт зардалд 126,815.1 мянга, эд хогшил худалдан авах зардалд 2,553.9 мянга, томилолтын зардалд 3,608.7 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 6,672.6 мянга, бараа үйлчилгээний бусад 147,401.9 мянга, урсгал шилжүүлгийн зардалд 264,000.0 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд тус байгууллагад Коронавирус (Ковид19) цар тахалтай холбоотой Эрүүл мэндийн яам, орон нутгийн төрийн байгууллага болон бусад байгууллага, иргэдээс ирсэн хандивын орлогоор 170,499.3 мянга, бараа материалаар 1,934,246.0 мянган төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгслийг орлого авч, аймгийн эрүүл мэндийн байгууллагуудад 1,890,979.2

мянган төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгслийг хуваарилж, 5,188.5 мянган төгрөгийн эм, тариа хугацаа дууссан тул акталж устгаж, 115,092.8 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Үндсэн хөрөнгө 655,391.0 мянган төгрөгийг дараах эх үүсвэрээр бэлтгэсэн байна. Үүнд:

1. Төсвийн хөрөнгөөр худалдаж авсан хөрөнгө: Компьютер /5ш/ - 12,500.0 мянган төгрөг,
2. Хандиваар болон шилжүүлэн авсан хөрөнгө: ЭМЯ-наас 19,655.5 мянган төгрөгийн компьютер /10/ -г үнэ төлбөргүй орлогоор, ХӨСҮТ-өөс 35,716.8 мянган төгрөгийн тоног төхөөрөмж /7ш/, аймгийн нэгдсэн эмнэлгээс 587,518.7 мянган төгрөгийн барилга, байгууламжийг шилжүүлэн авсан зэрэг нь байгууллагын нийт хөрөнгө их хэмжээгээр нэмэгдэхэд нөлөөлсөн байна.

3.8 Аудитын гол асуудал

Тайлант онд тус байгууллага “Эрүүл мэндийн бодлогын удирдлага” гэсэн 1 хөтөлбөр, 4 зориулалт арга хэмжээнд нийт 670,672.0 мянган төгрөгийн төлөвлөж, гүйцэтгэлийг хангаж ажилласан байна. Үүнд: 1. “Үндсэн үйл ажиллагааны зардал” зориулалт арга, хэмжээнд 423,606.7 мянган төгрөгөөс 411,988.5 мянган төгрөгийг зарцуулж, гүйцэтгэл нь 97.3 хувь, 2. “Гэрээгээр гүйцэтгэсэн ажил үйлчилгээ” зориулалт арга хэмжээнд 5,068.0 мянган төгрөгөөс 4,967.0 мянган төгрөгийг зарцуулж, гүйцэтгэл нь 98.0 хувь, 3. “Ажил олгогчоос олгох тэтгэмж урамшуулал”-д 237,554.4 мянган төгрөгийг төлөвлөснөөс 234,838.4 мянган төгрөгийг зарцуулж, гүйцэтгэл нь 98.9 хувь, хөтөлбөр, төслийн дотоод урсгал зардалд 4,342.9 мянган төгрөгийг тус төлөвлөж, 100.0 хувийн гүйцэтгэлтэй гарсан байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Тайлант онд шилэн дансны нэгдсэн системд байршуулбал зохих 149 мэдээллийг бүрэн байршуулсан нь Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хуулийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.9.2 Татварын ерөнхий хуулийн хэрэгжилт

Тайлант хугацаанд хийсэн худалдан авалтаас 181,147.1 мянган төгрөгийн бараа, ажил үйлчилгээний төлбөрийн баримтыг “И баримт” цахим төлбөрийн баримтын системд шивүүлж, баталгаажуулаагүй, 46,328.4 мянган төгрөгийн баримт илүү шивэгдсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн Татварын ерөнхий хуулийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 21,786.6 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага, 1 зөвлөмж өгсөн ба албан шаардлага нь бүрэн биелсэн байна. И баримт цахим төлбөрийн баримтын системд худалдан авалтын төлбөрийн баримтын шивэлттэй холбоотой өгсөн 1 зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй байгаагаас тайлант онд уг зөрчил давтагдсан байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Тайлант онд улс орныг хамарсан Ковид-19 цар тахлын улмаас аудитыг цахимаар хийж байгаагаас шалтгаалан байгууллага дээр ажиллаж нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэх, хөрөнгийн биет тооллого хийх гэх мэт хөрөнгийн хяналтыг бүрэн хэрэгжүүлэх, бараа материалын нөөц, үлдэгдлийн шалтгааныг нарийвчлан тогтоох нөхцөл байдал хязгаарлагдмал байсныг дараагийн тайлант хугацаанд анхаарах нь зүйтэй гэж үзлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 327,892.8 мянган төгрөгийн 6 алдаа зөрчил илэрснээс 5,394.0 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 97,296.2 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага, 225,202.6 мянган төгрөгийн зөрчилд 4 зөвлөмжийг тус тус өгсөн бөгөөд залруулагдаагүй 327,892.8 мянган төгрөгийн алдаа зөрчил нь тогтоосон материаллаг байдлын түвшинээс 313,961.1 мянган төгрөгөөр их байгаа тул “Хязгаарлалттай” дүгнэлт өглөө.

4.1 Залруулсан алдаагүй

4.2 Төлбөрийн акт

4.2.1 Байгууллагын ажиллагсад Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолд тусгагдаагүй, ажлын байрны тодорхойлолтод заагдсан ажлуудыг илүү цагаар ажилласнаар тооцож, 5,394.0 мянган төгрөгийг илүү олгож, үргүй зардал гаргасан нь Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолоор батлагдсан төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журмын 4 дүгээр зүйл "Хөдөлмөрийн тухай хуульд заасны дагуу дор дурдсанаас бусад тохиолдолд төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийг ажил олгогчийн санаачилгаар илүү цагаар ажиллуулахыг хориглоно" 4.1 "Улс орныг батлан хамгаалах, хүний амь бие, эрүүл мэндийг хамгаалахад зайлшгүй шаардлагатай ажил үүрэг гүйцэтгүүлэх" гэсэнтэй нийцээгүй.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох.

4.3 Албан шаардлага

4.3.1 Бараа материалын дансдад үндсэн хөрөнгийн шинж чанартай 97,296.2 мянган төгрөгийн хөрөнгийг буруу ангилан бүртгэсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 “үнэн зөв байх”, Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавартай нийцээгүй, “Ангилал” батламж мэдэгдэл “ажил гүйлгээ, үйл явдлыг зөв дансанд ангилж бүртгэсэн байх” гэснийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх

4.4. Зөвлөмж

1. Төсвийн зарцуулалттай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Холбогдох эрх бүхий байгууллага, албан тушаалтны шийдвэргүйгээр бараа үйлчилгээний бусад зардлаас 4,324.5 мянган төгрөгийн бараа материал бэлтгэж, баталсан зардлыг бүлэг хооронд шилжүүлэн зарцуулсан. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэсэнтэй нийцээгүй.

1.2. Өгсөн зөвлөмж:

Зардлыг бүлэг хооронд шилжүүлэн зарцуулахдаа дээд шатны байгууллагаар дамжуулан Санхүү, төрийн сангийн асуудал хариуцсан байгууллагын шийдвэр болон дээд шатны төсвийн захирагчийн зөвшөөрлийг албан бичгээр авсан байх.

2. Төсвийн зарцуулалттай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

а) Өмнөх оны НДШ-ийн авлага, өглөгийн тооцоог үнэн зөв бүртгэж тайлагнаагүйгээс шалтгаалан санхүүгийн үр дүнгийн тайлан 117.8 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлэгдсэн, б) Санхүүгийн үр дүнгийн тайланд 39,613.2 мянган төгрөгийн үнэ төлбөргүй гарсан зардлыг буруу бүртгэж тайлагнасан. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 "үнэн зөв байх", Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавартай нийцээгүй, "Ангилал" батламж мэдэгдэл "ажил гүйлгээ, үйл явдлыг зөв дансанд ангилж бүртгэсэн байх" гэснийг хангахгүй байна.

2.2. Өгсөн зөвлөмж:

Санхүүгийн бүртгэл тайлагналыг үнэн зөв ангилж бүртгэж тайлагнах.

3. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын бичиг баримттай холбоотой

3.1. Илрүүлэлт: Байгууллагын нягтлан бодох бодлогын баримт бичиг холбогдох хууль тогтоомж, стандартын шаардлага хангаагүй, байгууллагын бүртгэлийн онцлогт тохироогүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2. "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана" гэсэнтэй нийцээгүй байна.

3.2. Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлэн батлуулах

4. Худалдан авалттай холбоотой асуудал

4.1. Илрүүлэлт:

Тайлант хугацаанд хийсэн худалдан авалтаас 181,147.1 мянган төгрөгийн бараа, ажил үйлчилгээний төлбөрийн баримтыг "И баримт" цахим төлбөрийн баримтын системд шивүүлж, баталгаажуулаагүй, 46.328.4 мянган төгрөгийн баримт илүү шивэгдсэн байна. Энэ нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.5-д: "Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх эсхүл цахимаар илгээх үүрэгтэй" гэсэнтэй нийцэхгүй байна.

4.2. Өгсөн зөвлөмж:

Худалдан авалтын төлбөрийн баримтыг цахим төлбөрийн баримтын системд тухай бүр үнэн зөв шивүүлж байх.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

| | | /МЯН.ТӨГ/ | | | | | | | | | |
|----------|---|----------------------|-----------|-----------|-----|---------------|---------|-----------------|----------|---------|-----------|
| д/д | Зөрчлийн утга | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Санхүүгийн тайлангийн аудитын асуудал | | | | | | | | | | |
| 1.1 | Байгууллагын ажиллагсад Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолд тусгагдаагүй, ажлын байрны тодорхойлолтод заагдсан ажлуудыг илүү цагаар ажилласнаар тооцож, 13,239.9 мянган төгрөгийг илүү олгож, үргүй зардал гаргасан | 1 | 5,394.0 | | | 1 | 5,394.0 | | | | |
| 1.2 | Бараа материалын дансад үндсэн хөрөнгийн шинж чанартай 97,296.2 мянган төгрөгийн хөрөнгийг буруу ангилан бүртгэсэн | 1 | 97,296.2 | | | | | 1 | 97,296.2 | | |
| 1.3 | Байгууллагын нягтлан бодох бодлогын баримт бичиг холбогдох хууль тогтоомж, стандартын шаардлага хангаагүй, байгууллагын бүртгэлийн онцлогт тохироогүй | 1 | 0.0 | | | | | | | 1 | 0.0 |
| 1.4 | Холбогдох эрх бүхий байгууллага, албан тушаалтны шийдвэргүйгээр бараа үйлчилгээний бусад зардлаас бараа материал бэлтгэж, баталсан зардлыг бүлэг хооронд шилжүүлэн зарцуулсан | 1 | 4,324.5 | | | | | | | 1 | 4,324.5 |
| 1.5 | Санхүүгийн үр дүнгийн тайлан 117.8 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлэгдсэн | 1 | 117.8 | | | | | | | 1 | 117.8 |
| 1.6 | Санхүүгийн үр дүнгийн тайланд 39,613.2 мянган төгрөгийн үнэ төлбөргүй гарсан зардлыг буруу бүртгэж тайлагнасан. | 1 | 39,613.2 | | | | | | | 1 | 39,613.2 |
| 2 | Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал | | | | | | | | | | |
| 2.1 | Е баримт цахим төлбөрийн системд төлбөрийн баримтыг шивүүлэхдээ 181,147.1 мянган төгрөгийн төлбөрийн баримтыг шивүүлж, баталгаажуулаагүй | 1 | 181,147.1 | | | | | | | 1 | 181,147.1 |
| НИЙТ ДҮН | | 7 | 327,892.8 | | | 1 | 5,394.0 | 1 | 97,296.2 | 5 | 225,202.6 |